



ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

№ 1 (430)

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

- *Зарим хүмүүсийг аймгийн шүүхийн шүүгч, ерөнхий шүүгчийн албан тушаалд томилох тухай*
- *Шүүхийн сахилгын хорооны бүрэлдэхүүнийг батлах тухай*
- *Зарим хүмүүсийг одон, медалиар шагнах тухай*

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

- *Үндэсний хөтөлбөр (журам) батлах тухай*

Улсын Их Хурлын Тамгын газар

Улаанбаатар хот

2006 он



ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ
Долоо хоног тутмын

Улаанбаатар хот

2006 оны нэгдүгээр сарын 7

№1 (430)

Гарчиг

Нэг. МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

- | | | | |
|----|---|-----------|---|
| 1. | Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай | Дугаар 73 | 2 |
|----|---|-----------|---|

Хоёр. МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

- | | | | |
|-----|---|------------|---|
| 2. | Зарим хүмүүсийг аймгийн шүүхийн шүүгч, ерөнхий шүүгчийн албан тушаалд томилох тухай | Дугаар 119 | 2 |
| 3. | Зарим хүмүүсийг аймгийн Захиргааны хэргийн шүүхийн шүүгчийн албан тушаалд томилох тухай | Дугаар 120 | 3 |
| 4. | Зарим хүмүүсийг сум дундын шүүхийн шүүгчийн албан тушаалд томилох тухай | Дугаар 121 | 3 |
| 5. | Зарим хүмүүсийг сум, сум дундын шүүхийн шүүгч, ерөнхий шүүгчийн албан тушаалд томилох тухай | Дугаар 122 | 3 |
| 6. | Зарим хүмүүсийг шүүгч, ерөнхий шүүгчийн албан тушаалаас чөлөөлөх тухай | Дугаар 123 | 4 |
| 7. | Дипломат цол олгох тухай | Дугаар 124 | 4 |
| 8. | Зарим хүмүүсийг Улсын дээд шүүхийн шүүгчийн албан тушаалд томилох тухай | Дугаар 126 | 4 |
| 9. | Нийслэлийн шүүхийн шүүгчийн албан тушаалаас чөлөөлөх тухай | Дугаар 127 | 4 |
| 10. | Дашрэнцэнгийн Самбууд Монгол Улсын ардын жүжигчин цол хүртээх тухай | Дугаар 128 | 5 |
| 11. | Балдангийн Долгормаад Монгол Улсын гавьяат эдийн засагч цол хүртээх тухай | Дугаар 129 | 5 |
| 12. | Түндэвийн Зэвгээд Монгол Улсын гавьяат багш цол хүртээх тухай | Дугаар 130 | 5 |
| 13. | Гүрбазарын Амарт Монгол Улсын соёлын гавьяат зүтгэлтэн цол хүртээх тухай | Дугаар 131 | 5 |
| 14. | Бэх-Очирын Жаргалсайханд Монгол Улсын гавьяат жүжигчин цол хүртээх тухай | Дугаар 132 | 6 |
| 15. | Гэлэжамцын Лувсанцэрэнд Монгол Улсын шинжлэх ухааны гавьяат зүтгэлтэн цол хүртээх тухай | Дугаар 133 | 6 |
| 16. | Баатарын Жүгдэрт Монгол Улсын гавьяат барилгачин цол хүртээх тухай | Дугаар 134 | 6 |
| 17. | Шаравын Гунгаадоржид Монгол Улсын гавьяат агрономич цол хүртээх тухай | Дугаар 135 | 6 |
| 18. | Лувсанбалдангийн Нямсамбууд Монгол Улсын гавьяат эдийн засагч цол хүртээх тухай | Дугаар 136 | 7 |
| 19. | Самбуугийн Дэмбэрэлд Монгол Улсын гавьяат эдийн засагч цол хүртээх тухай | Дугаар 137 | 7 |
| 20. | Баянсангийн Үржинхандад Монгол Улсын аж үйлдвэрийн гавьяат ажилтан цол хүртээх тухай | Дугаар 138 | 7 |

21.	Дашзэвэгийн Намжилмаад Монгол Улсын гавьяат тамирчин цол хүртээх тухай	Дугаар 139	7
22.	Нямжавын Цэвэгниямд Монгол Улсын гавьяат тамирчин цол хүртээх тухай	Дугаар 140	8
23.	Зарим хүмүүсийг одон, медалиар шагнах тухай	Дугаар 141	8
24.	Шүүхийн сахилгын хорооны бүрэлдэхүүнийг батлах тухай	Дугаар 143	11

Гурав. МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

25.	Үндэсний хөтөлбөр (журам) батлах тухай	Дугаар 215	12
-----	--	------------	----

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2005 оны 12 дугаар сарын 01–ний өдөр

Дугаар 73

Улаанбаатар хот

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай

Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль батлагдсантай холбогдуулан дараахь арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар /Ц.Элбэгдорж/-т даалгасугай:

1/ төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагаанд дагаж мөрдөх журам, дүрэм, эрх зүйн бусад актыг хуульд нийцүүлэн 2006 оны 1 дүгээр сард багтаан шинэчилж батлах;

2/ худалдан авах ажиллагааны удирдлага, хяналт, шинжилгээ, улсын хэмжээнд хийгдэж байгаа худалдан авалтын талаархи мэдээллийн сан бий болгож, ашиглах нөхцөл бүрдүүлэх;

3/ Засгийн газрын байгууллагуудын худалдан авах ажиллагааны ил тод байдал, үр ашгийг нэмэгдүүлэх зорилгоор цахим технологи болон мэдээллийн технологийн ололтыг худалдан авах ажиллагаанд нэвтрүүлэх ажлыг зохион байгуулж хэрэгжүүлэх;

4/ төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлэх боловсон хүчний нөөцийн чадавхи, мэргэшлийг сайжруулах, хувийн хэвшил, олон нийтийн дунд худалдан авах ажиллагааны тухай хууль тогтоомж, эрх зүйн актыг сурталчлах, сургалт зохион байгуулах.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА

Ц.НЯМДОРЖ

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2005 оны 12 дугаар сарын 21–ний өдөр

Дугаар 119

Улаанбаатар хот

Зарим хүмүүсийг аймгийн шүүхийн шүүгч, Ерөнхий шүүгчийн албан тушаалд томилох тухай

"Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай" хуулийн 12 дугаар зүйлийн 16, "Шүүхийн тухай" Монгол Улсын хуулийн 32 дугаар зүйлийн 1, 4, 6 дахь хэсгийг тус тус баримтлан, Шүүхийн ерөнхий зөвлөлийн саналыг үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь:

1. Амгалангийн Насандэлгэрийг Говь-Алтай аймгийн шүүхийн шүүгч, ерөнхий шүүгчийн, Пүрэвсүрэнгийн Батсайханыг Орхон аймгийн шүүхийн шүүгч, ерөнхий шүүгчийн, Бамбарын Баасанхүүг Өвөрхангай аймгийн шүүхийн шүүгч, ерөнхий шүүгчийн, Агвааны Сугарсүрэнг Өмнөговь аймгийн шүүхийн шүүгч, ерөнхий шүүгчийн,

Зундуйн Хосбаярыг Хөвсгөл аймгийн шүүхийн шүүгч, ерөнхий шүүгчийн албан тушаалд тус тус томилсугай.

2. Райханы Асхабылийг Баян-Өлгий аймгийн шүүхийн ерөнхий шүүгчийн, Лувсангийн Баярааг Сэлэнгэ аймгийн шүүхийн ерөнхий шүүгчийн албан тушаалд тус тус улируулан томилсугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ

Н.ЭНХБАЯР



МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2005 оны 12 дугаар сарын 23—ны өдөр

Дугаар 120

Улаанбаатар хот

Зарим хүмүүсийг аймгийн Захиргааны хэргийн шүүхийн шүүгчийн албан тушаалд томилох тухай

"Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай" хуулийн 12 дугаар зүйлийн 16, "Шүүхийн тухай" Монгол Улсын хуулийн 32 дугаар зүйлийн 1 дэх хэсгийг тус тус баримтлан, Шүүхийн ерөнхий зөвлөлийн саналыг үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь:

Сламын Сайраныг Баян-Өлгий аймгийн Захиргааны хэргийн шүүхийн шүүгчийн, Гомбодоржийн Гантуяаг Булган аймгийн Захиргааны хэргийн шүүхийн шүүгчийн, Жамъянхоролын

Оюунчимэгийг Дархан-Уул аймгийн Захиргааны хэргийн шүүхийн шүүгчийн, Чирчингийн Одсүрэнг Хэнтий аймгийн Захиргааны хэргийн шүүхийн шүүгчийн, Доржготовын Чанцалнямыг Төв аймгийн Захиргааны хэргийн шүүхийн шүүгчийн албан тушаалд тус тус томилсугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ

Н.ЭНХБАЯР

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2005 оны 12 дугаар сарын 23—ны өдөр

Дугаар 121

Улаанбаатар хот

Зарим хүмүүсийг сум дундын шүүхийн албан тушаалд томилох тухай

"Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай" хуулийн 12 дугаар зүйлийн 16, "Шүүхийн тухай" Монгол Улсын хуулийн 32 дугаар зүйлийн 1 дэх хэсгийг тус тус баримтлан, Шүүхийн ерөнхий зөвлөлийн саналыг үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь:

Батмөнхийн Болор-Эрдэнийг Баянхонгор аймаг дахь сум дундын шүүхийн шүүгчийн, Лхаажавын Дашдэлзгийг Говь-Алтай аймаг дахь сум дундын шүүхийн шүүгчийн, Сүхбаатарын Сэржмядаг, Даваагийн Уранчимэг нарыг Дундговь аймаг дахь сум дундын шүүхийн шүүгчийн, Лхамсүрэнгийн Алтанг Увс аймаг дахь сум дундын

шүүхийн шүүгчийн, Намдагсүрэнгийн Батсайхан, Түмэндэмбэрэлийн Хүрэлбаатар нарыг Хөвсгөл аймаг дахь сум дундын шүүхийн шүүгчийн, Төмөрбаатарын Болормааг Хэнтий аймаг дахь сум дундын 2 дугаар шүүхийн шүүгчийн, Батнасангийн Мөнхжаргалыг Өмнөговь аймаг дахь сум дундын шүүхийн шүүгчийн, Эрдэнэ-Очирын Болормааг Дорноговь аймаг дахь сум дундын 2 дугаар шүүхийн шүүгчийн албан тушаалд тус тус томилсугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ

Н.ЭНХБАЯР

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2005 оны 12 дугаар сарын 23—ны өдөр

Дугаар 122

Улаанбаатар хот

Зарим хүмүүсийг сум, сум дундын шүүхийн шүүгч, ерөнхий шүүгчийн албан тушаалд томилох тухай

"Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай" хуулийн 12 дугаар зүйлийн 16, "Шүүхийн тухай" Монгол Улсын хуулийн 32 дугаар зүйлийн 1, 4, 6 дахь хэсгийг тус тус баримтлан, Шүүхийн ерөнхий зөвлөлийн саналыг үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь:

1. Батбайн Мангилийг Баян-Өлгий аймаг дахь сум дундын шүүхийн ерөнхий шүүгчийн, Жигмэддоржийн Долормааг Дорнод аймаг дахь Хэрлэн сумын шүүхийн шүүгч, ерөнхий шүүгчийн, Доржлагамын Сугарыг Сүхбаатар аймаг дахь сум дундын шүүхийн ерөнхий шүүгчийн, Магсарын Нармандахыг Хөвсгөл аймаг дахь сум дундын

шүүхийн ерөнхий шүүгчийн албан тушаалд тус тус томилсугай.

2. Данзангийн Сарантуяаг Говь-Алтай аймаг дахь сум дундын шүүхийн Ерөнхий шүүгчийн, Бадарчийн Бямбахоорлоог Сэлэнгэ аймаг дахь сум дундын 2 дугаар шүүхийн Ерөнхий шүүгчийн, Жамбалын Мөнхтуяаг Төв аймаг дахь сум дундын 1 дүгээр шүүхийн Ерөнхий шүүгчийн албан тушаалд тус тус улируулан томилсугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ

Н.ЭНХБАЯР

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2005 оны 12 дугаар сарын 23—ны өдөр

Дугаар 123

Улаанбаатар хот

Зарим хүмүүсийг шүүгч, ерөнхий шүүгчийн албан тушаалаас чөлөөлөх тухай

"Шүүхийн тухай" Монгол Улсын хуулийн 58 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1, 2 дахь заалтуудыг баримтлан, Шүүхийн ерөнхий зөвлөлийн саналыг үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь:

Өөрөө хүсэлт гаргасан Цэрэндоржийн Баасанжавыг Завхан аймаг дахь сум дундын 2 дугаар шүүхийн шүүгч, Ерөнхий шүүгчийн, төрийн өөр ажил, албан тушаалд томилогдох болсон Амгалангийн Насандэлгэрийг Баянхонгор аймгийн шүүхийн шүүгчийн, Пүрэвсүрэнгийн Батсайханыг Сэлэнгэ аймаг дахь сум дундын 1 дүгээр шүүхийн шүүгч, Ерөнхий шүүгчийн, Бамбарын Баасанхүүг Говь-Алтай аймгийн шүүхийн шүүгчийн, Агвааны Сугарсүрэнг Дундговь аймгийн шүүхийн шүүгчийн,

Зундуйн Хосбаярыг Булган аймаг дахь сум дундын шүүхийн шүүгч, Ерөнхий шүүгчийн, Жигмэддоржийн Долормааг Дорнод аймгийн шүүхийн шүүгчийн, Сламын Сайраныг Баян-Өлгий аймаг дахь сум дундын шүүхийн шүүгчийн, Доржготовын Чанцалнямыг Хэнтий аймгийн Захиргааны хэргийн шүүхийн шүүгчийн, Батнасангийн Мөнхжаргалыг Дорноговь аймаг дахь сум дундын 2 дугаар шүүхийн шүүгчийн, Эрдэнэ-Очирын Болормааг Дорнод аймаг дахь Хэрлэн сумын шүүхийн шүүгчийн албан тушаалаас тус тус чөлөөлсүгэй.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ

Н.ЭНХБАЯР

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2005 оны 12 дугаар сарын 27—ны өдөр

Дугаар 124

Улаанбаатар хот

Дипломат цол олгох тухай

Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Дипломат албаны тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийг баримтлан ЗАРЛИГ БОЛГОХ нь:

Гадаад хэргийн яамны Олон талт хамтын ажиллагааны газрын захирал Очирын Энхцэцэг, Монгол Улсаас Бүгд Найрамдах Ардчилсан

Солонгос Ард Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Жанчивдоржийн Ломбо нарт "Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин" цол тус тус олгосугай.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ

Н.ЭНХБАЯР

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2005 оны 12 дугаар сарын 29—ний өдөр

Дугаар 126

Улаанбаатар хот

Зарим хүмүүсийг Улсын дээд шүүхийн шүүгчийн албан тушаалд томилох тухай

"Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай" хуулийн 12 дугаар зүйлийн 16, "Шүүхийн тухай" Монгол Улсын хуулийн 32 дугаар зүйлийн 2 дахь хэсгийг тус тус баримтлан, Шүүхийн ерөнхий зөвлөлийн саналыг үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь:

Батбуяангийн Бат-Эрдэнэ, Лувсандоржийн Баябаа, Батсүрэнгийн Ундрах нарыг Улсын дээд шүүхийн шүүгчээр тус тус томилсугай.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ

Н.ЭНХБАЯР

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2005 оны 12 дугаар сарын 29—ний өдөр

Дугаар 127

Улаанбаатар хот

Нийслэлийн шүүхийн шүүгчийн албан тушаалаас чөлөөлөх тухай

"Шүүхийн тухай" Монгол Улсын хуулийн 58 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 2 дахь заалтыг баримтлан, Шүүхийн ерөнхий зөвлөлийн саналыг үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь:

Улсын дээд шүүхийн шүүгчээр томилогдсон тул Лувсандоржийн Бямбаа, Батсүрэнгийн Ундрах

нарыг Нийслэлийн шүүхийн шүүгчийн албан тушаалаас тус тус чөлөөлсүгэй.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ

Н.ЭНХБАЯР

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2005 оны 12 дугаар сарын 29-ний өдөр

Дугаар 128

Улаанбаатар хот

Дашцэрэнгийн Самбууд Монгол Улсын ардын жүжигчин цол хүртээх тухай

Мэргэжлийн урлагийн байгууллагад гоцлол дуучнаар олон жил үр бүтээлтэй ажиллаж монгол ардын уртын болон богинын, зохиолын дуунуудыг чадварлаг дуулж урын сангаа баяжуулан, монголын дууны урлагийг хөгжүүлэхэд оруулж байгаа дорвитой хувь нэмрийг нь үнэлж дуучин Дашцэрэнгийн Самбууд Монгол Улсын ардын жүжигчин цол хүртээсүгэй.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ

Н.ЭНХБАЯР

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2005 оны 12 дугаар сарын 29-ний өдөр

Дугаар 129

Улаанбаатар хот

Балдангийн Долгормаад Монгол Улсын гавьяат эдийн засагч цол хүртээх тухай

Сангийн яам болон санхүү, эдийн засгийн сургуулиудад он удаан жил үр бүтээлтэй ажиллаж улс орны эдийн засаг, санхүү төсөв, мөнгө зээл, бүртгэл, даатгалын системийг боловсронгуй болгох, мэргэжлийн боловсон хүчин бэлтгэхэд оруулсан хувь нэмрийг нь үнэлж Улаан-Үдийн Их сургуулийн Улаанбаатар дахь салбарын багш Балдангийн Долгормаад Монгол Улсын гавьяат эдийн засагч цол хүртээсүгэй.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ

Н.ЭНХБАЯР

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2005 оны 12 дугаар сарын 29-ний өдөр

Дугаар 130

Улаанбаатар хот

Түндэвийн Зэвгээд Монгол Улсын гавьяат багш цол хүртээх тухай

ЭМШУИС-д багш, тэнхмийн эрхлэгчээр он удаан жил үр бүтээлтэй ажиллаж, эрдэм судлалын бүтээлүүд туурвин, эмгэг физиологийн хичээлийн сургалтын агуулга, арга зүйг боловсронгуй болгох, эрүүл мэндийн салбарын мэргэжлийн боловсон хүчин бэлтгэх үйлст оруулж байгаа хувь нэмрийг нь үнэлж ЭМШУИС-ийн Эрүүл ба эмгэг физиологийн тэнхмийн багш Түндэвийн Зэвгээд Монгол Улсын гавьяат багш цол хүртээсүгэй.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ

Н.ЭНХБАЯР

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2005 оны 12 дугаар сарын 29-ний өдөр

Дугаар 131

Улаанбаатар хот

Гүрбазарын Амарт Монгол Улсын соёлын гавьяат зүтгэлтэн цол хүртээх тухай

Соёлын байгууллагуудад олон жил үр бүтээлтэй ажиллаж дэлхийн зарим орны уран зохиолын ба нийгэм-улс төр, спорт, хүүхдийн зохиол зэрэг янз бүрийн сэдэвтэй номуудыг орчуулж, орчуулгыг ариутган шүүж, монголын уншигч түмний оюуны санд оруулж байгаа хувь нэмрийг нь үнэлж орчуулагч Гүрбазарын Амарт Монгол Улсын соёлын гавьяат зүтгэлтэн цол хүртээсүгэй.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ

Н.ЭНХБАЯР

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2005 оны 12 дугаар сарын 29—ний өдөр

Дугаар 132

Улаанбаатар хот

Бэх-Очирын Жаргалсайханд Монгол Улсын гавьяат жүжигчин цол хүртээх тухай

Мэргэжлийн урлагийн байгууллагад үр бүтээлтэй ажиллаж дэлхийн сонгодог болон үндэсний жүжиг, кино, тележүжгийн олон гол, туслах дүрийг мэргэжлийн өндөр түвшинд бүтээж манай тайз, дэлгэцийн урлагийг хөгжүүлэхэд оруулж байгаа хувь нэмрийг нь үнэлж Улсын драмын

эрдмийн театрын жүжигчин Бэх-Очирын Жаргалсайханд Монгол Улсын гавьяат жүжигчин цол хүртээсүгэй.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ

Н.ЭНХБАЯР

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2005 оны 12 дугаар сарын 29—ний өдөр

Дугаар 133

Улаанбаатар хот

Гэлэгжамцын Лувсанцэрэнд Монгол Улсын шинжлэх ухааны гавьяат зүтгэлтэн цол хүртээх тухай

Боловсрол, шинжлэх ухааны болон төрийн бус байгууллагад он удаан жил үр бүтээлтэй ажиллаж монголын буддын гүн ухааны түүхийн талаар судалгаа явуулж, эрдэм судлалын бүтээлүүд туурвин, энэ чиглэлийн эрдэмтэн судлаачдыг бэлтгэхэд оруулж байгаа хувь нэмрийг нь үнэлж ШУА-ийн Философи, социологи, эрхийн

хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан Гэлэгжамцын Лувсанцэрэнд Монгол Улсын шинжлэх ухааны гавьяат зүтгэлтэн цол хүртээсүгэй.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ

Н.ЭНХБАЯР

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2005 оны 12 дугаар сарын 29—ний өдөр

Дугаар 134

Улаанбаатар хот

Баатарын Жүгдэрт Монгол Улсын гавьяат барилгачин цол хүртээх тухай

Монголын барилгын ууган томоохон байгууллагыг олон жил чадварлаг удирдан зохион байгуулж үйлдвэрлэл, үйлчилгээ, орон сууцны барилгуудыг чанартай барьж ашиглалтад оруулан, барилгын үйлдвэрлэлийг хөгжүүлэхэд оруулж байгаа хувь нэмрийг нь үнэлж “Улаанбаатар

барилга” ХК-ийн гүйцэтгэх захирал Баатарын Жүгдэрт Монгол Улсын гавьяат барилгачин цол хүртээсүгэй.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ

Н.ЭНХБАЯР

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2005 оны 12 дугаар сарын 29—ний өдөр

Дугаар 135

Улаанбаатар хот

Шаравын Гунгаадоржид Монгол Улсын гавьяат агрономч цол хүртээх тухай

Төр, захиргааны төв байгууллагад олон жил санаачилга, үр бүтээлтэй ажиллаж манай улсын газар тариалангийн үйлдвэрлэлийг хөгжүүлэх, тус салбарын удирдлага, зохион байгуулалт, эрх зүйн орчинг боловсронгуй болгоход оруулж байгаа хувь нэмрийг нь үнэлж Байгаль орчны сайдын зөвлөх

Шаравын Гунгаадоржид Монгол Улсын гавьяат агрономч цол хүртээсүгэй.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ

Н.ЭНХБАЯР

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2005 оны 12 дугаар сарын 29-ний өдөр

Дугаар 136

Улаанбаатар хот

Лувсанбалдангийн Нямсамбууд Монгол Улсын гавьяат эдийн засагч цол хүртээх тухай

Барилга, хөдөө аж ахуйн төв байгууллага болон төрийн бус байгууллагад олон жил санаачилга, үр бүтээлтэй ажиллаж хувийн хэвшлийг хөгжүүлэх, шинэ тутам байгуулагдсан ажил олгогчдын байгууллагыг нийгэм болон гишүүдэд үйлчлэх үндэсний хэмжээний байгууллага болгон төлөвшүүлэхэд оруулж байгаа

хувь нэмрийг нь үнэлж Монголын ажил олгогч эздийн нэгдсэн холбооны ерөнхийлөгч Лувсанбалдангийн Нямсамбууд Монгол Улсын гавьяат эдийн засагч цол хүртээсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ**
Н.ЭНХБАЯР

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2005 оны 12 дугаар сарын 29-ний өдөр

Дугаар 137

Улаанбаатар хот

Самбуугийн Дэмбэрэлд Монгол Улсын гавьяат эдийн засагч цол хүртээх тухай

Монгол улсын гадаад, дотоод худалдааны салбарт олон жил санаачилга, үр бүтээлтэй ажиллаж хувийн хэвшлийг хөгжүүлэх, бизнесийн таатай орчинг бүрдүүлэхэд чиглэгдсэн олон ажлыг удирдан зохион байгуулж, улсын эдийн засагт оруулж байгаа хувь нэмрийг нь үнэлж Монголын

үндэсний худалдаа, аж үйлдвэрийн танхимын дарга Самбуугийн Дэмбэрэлд Монгол Улсын гавьяат эдийн засагч цол хүртээсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ**
Н.ЭНХБАЯР

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2005 оны 12 дугаар сарын 29-ний өдөр

Дугаар 138

Улаанбаатар хот

Баянсангийн Үржинхандад Монгол Улсын аж үйлдвэрийн гавьяат ажилтан цол хүртээх тухай

Хүнсний үйлдвэрийн салбарт олон жил үр бүтээлтэй ажиллаж үйлдвэрлэлд шинэ техник, технологи нэвтрүүлэн, хүн амыг стандартын шаардлага хангасан, чанарын баталгаатай хүнсний бүтээгдэхүүнээр хангахад оруулж байгаа хувь нэмрийг нь үнэлж Сэлэнгэ аймаг дахь "Спирт бал

бурам" ХХК-ийн Спиртийн үйлдвэрийн технологич Баянсангийн Үржинхандад Монгол Улсын аж үйлдвэрийн гавьяат ажилтан цол хүртээсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ**
Н.ЭНХБАЯР

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2005 оны 12 дугаар сарын 29-ний өдөр

Дугаар 139

Улаанбаатар хот

Дашзэвгийн Намжилмаад Монгол Улсын гавьяат тамирчин цол хүртээх тухай

Биеийн тамир, спорт, боловсролын байгууллагад олон жил үр бүтээлтэй ажиллаж зэрэнцэг шидэлт, бөөрөнцөг түлхэлтээр олимп, дэлхий, тивийн аварга болон улсын аварга шалгаруулах тэмцээнд удаа дараа амжилттай оролцож улсын рекорд амжилтыг зуу гаруй удаа шинэчлэн тогтоож, улсын аварга 25 удаа болж

спортын өндөр амжилт гаргасныг үнэлж Мон-Алтиус БТДС-ийн захирал Дашзэвгийн Намжилмаад Монгол Улсын гавьяат тамирчин цол хүртээсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ**
Н.ЭНХБАЯР



МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2005 оны 12 дугаар сарын 29-ний өдөр

Дугаар 140

Улаанбаатар хот

Нямжавын Цэвэгнямд Монгол Улсын гавьяат тамирчин цол хүртээх тухай

Мэргэжлийн сумо бөхийн барилдааны үр чадварыг чадамгай эзэмшин амжилтаа ахиулан, спортын өндөр амжилт гаргаж байгааг нь үнэлж сумо бөхийн тамирчин Нямжавын Цэвэгням

(Кюкүтэнхо)-д Монгол Улсын гавьяат тамирчин цол хүртээсүгэй.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ

Н.ЭНХБАЯР

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2005 оны 12 дугаар сарын 29-ний өдөр

Дугаар 141

Улаанбаатар хот

Зарим хүнийг одон, медалиар шагнах тухай

Үйлдвэрлэл, худалдаа, үйлчилгээ, боловсрол, соёл, шинжлэх ухаан, эрүүл мэнд, татвар, даатгал, хөдөө аж ахуй, уул уурхай, эрчим хүч, замын цагдаа, мэргэжлийн хяналт, иргэний

бүртгэл, нотариат, төр захиргааны болон төрийн бус байгууллагад олон жил санаачилга, үр бүтээлтэй ажиллаж байгаа дор дурдсан хүмүүсийг одон, медалиар шагнасугай.

СҮХБААТАРЫН ОДОНГООР:

Чимидийн Сэрээтэр - ШУА-ийн зөвлөх

ХӨДӨЛМӨРИЙН ГАВЬЯАНЫ УЛААН ТУГИЙН ОДОНГООР:

1. Мөнхбаярын Батбаатар - Монголын барилгачдын холбооны ерөнхийлөгч
2. Пандийн Бямбацэрэн - Үндэсний Статистикийн газрын дарга
3. Жовжидын Гаваа - Говь-Алтай аймгийн Мэргэжлийн хяналтын газрын дарга, улсын ахлах байцаагч
4. Пүрэвийн Даш - Онцгой байдлын Ерөнхий газрын дарга
5. Дөлгорын Лувсанцэрэн - Нийслэлийн Монгол-Оросын хамтарсан "Сан" дээд сургуулийн багш
6. Намсангийн Намсрайжав - Хэнтий аймгийн Дэлгэрхаан сумын "Хэрлэн тооно" багийн малчин

7. Шонхорын Пүрэвсүх - МАХН-ын Удирдах Зөвлөлд техникийн хэсгийн ахлагч, ерөнхий инженер
8. Цоодолын Цэндээхүү - Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын шинжээч
9. Зогсоолын Цэрэндулам - Нийслэлийн Баянгол дүүргийн 8 дугаар хорооны иргэн, ахмад багш
10. Жамцын Чойжанцан - Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын дарга, хурандаа
11. Гэлэгпилийн Чулуунбаатар - ШУА-ийн Философи социологийн эрхийн хүрээлэнгийн захирал, УИХ-ын даргын ажлын хэсгийн зөвлөх, ахлагч

ЦЭРГИЙН ГАВЬЯАНЫ УЛААН ТУГИЙН ОДОНГООР:

НацагдоогийнБаяраа - Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын ахлах референт

"АЛТАН ГАДАС" ОДОНГООР:

1. Мадигийн Абай - "Баруун бүсийн цахилгаан дамжуулах сүлжээ" ХК-ийн Баян-Өлгий аймаг дахь салбарын засварын мастер
2. Төмөрийн Алагсай - Иргэний бүртгэл, мэдээллийн улсын төвийн компьютерийн инженер
3. Готовын Амарсанаа - Улсын мэргэжлийн хяналтын газрын үйлчилгээ, хамгаалалт хариуцсан ажилтан
4. Дугаржавын Баасансүрэн - Нийслэлийн МАХН-ын хорооны дэд дарга

5. Дамбын Баасанхүү - Сангийн яамны Төсвийн бодлогын газрын дарга
6. Баасанхүүгийн Батжаргал - Нийслэлийн хүнсний үйлдвэрлэлийн "Атар-Өргөө" ХК-ийн тоног төхөөрөмжийн засварчин
7. Намсрайн Болдбаатар - МАХН-ын дэргэдэх нийгэм улс төр, судалгааны "Прогноз" хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан
8. Жамбалсүрэнгийн Бямбаа - ЗХ-ийн биеийн тамир спорт хорооны "Алдар" нийгэмлэгийн зөвлөх дасгалжуулагч

9. Цагааны Володя - Бодлого судлалын төвийн зөвлөх

10. Дамбийжанцангийн Воршилов - Нийслэлийн худалдаа, үйлдвэрлэл, үйлчилгээний "Травел линк" ХХК-ийн захирал

11. Пэрэнлэйн Ганчимэг - Сангийн яамны Төсвийн бодлого, зохицуулалтын газрын орлогын хэлтсийн дарга

12. Совдын Дамдин - Улсын драмын эрдмийн театрын жүжигчин

13. Дашийн Дашцэцэг - Нийслэлийн Газрын албаны газрын үнэлгээ, төлбөрийн хэлтсийн дарга

14. Чимэдийн Дашчирэв - Улсын мэргэжлийн хяналтын газрын улсын ахлах байцаагч

15. Даваасамбуугийн Долгосүрэн - Нийслэлийн Баянзүрх дүүргийн тойргийн нотариатч

16. Мягмарын Есөнмөнх - Монголын хүүхэд залуучуудын хөгжлийн сангийн ерөнхийлөгч

17. Баасанжавын Жамбалдорж - Төв аймгийн Эрдэнэ сумын Засаг дарга

18. Төмөрийн Жамъяндагва - Сэлэнгэ аймгийн "Амарбаясгалант" хийдийн хамба лам

19. Цанжидын Зэгдбазар - Говь-Алтай аймгийн зам засварын "Говь-Алтай-АЗЗА" ХК-ийн захирал

20. Чимэдхүүгийн Лиза - Нийслэлийн Эрүүл мэндийн "Оюуцэцэг" хувийн эмнэлгийн чих, хамар, хоолойн их эмч

21. Баасанжавын Лхагваа - ГХЯ-ны Төрийн захиргааны удирдлагын газрын зөвлөх

22. Сүрэнгийн Мягмардаш - Сангийн яамны Төсвийн бодлого, зохицуулалтын газрын төсвийн нэгтгэлийн хэлтсийн дарга

23. Чимээгийн Мэргээ - Нийслэлийн Чингэлтэй дүүргийн Татварын хэлтсийн татварын улсын байцаагч

24. Банзарын Надмид - ЭНЭШ Төвийн хүүхдийн чих, хамар, хоолойн тасгийн их эмч

25. Хүрэлийн Намжилсүрэн - ГХЯ-ны Дипломат байгууллагын үйлчилгээ, аж ахуйн газрын жолооч

26. Арьяагийн Нарангэрэл - Нийслэлийн Сүхбаатар дүүргийн 1 дүгээр цэцэрлэгийн эрхлэгч

27. Нямдэлэгийн Нацагдорж - Нийслэлийн барилгын үйлдвэрлэлийн "Пума" ХХК-ийн ерөнхий захирал

28. Шагдарын Нацагням - Нийслэлийн хөдөө аж ахуйн "Бөхөг" ХК-ийн худалдаа хариуцсан захирал, ТУЗ-ийн дарга

29. Паархүүгийн Норовлоо - ЭНЭШ төвийн эх баригч сувиллагч

30. Дамбасүрэнгийн Нямдорж - Монголын кино дэлгэцийн уран бүтээлч, зохиогчдын эрхийг хамгаалах нийгэмлэгийн гүйцэтгэх захирал

31. Баянжаргалын Отгон - Гэмтэл согог сэргээн засалтын клиникийн Түлэнхийн төвийн дэд захирал

32. Энэбишийн Оюунтэгш - Монголын үндэсний худалдаа, аж үйлдвэрийн танхимын ерөнхий нарийн бичгийн дарга

33. Бямбасүрэнгийн Өнөрбилэг - Төв аймгийн Заамар сум дахь уул уурхайн "Шижир алт" ХХК-ийн алтны үйлдвэрийн драгёр

34. Нэмэхийн Өсөх - Дархан-Уул аймгийн Татварын хэлтсийн нэг цэгийн үйлчилгээний улсын байцаагч

35. Дуламсүрэнгийн Пүрэвжав - Орхон аймгийн ҮЭ-ийн Холбооны зохион байгуулагч

36. Ендонгийн Пүрэвцэрэн - Улсын Нийгмийн даатгалын ерөнхий газрын хэлтсийн дарга

37. Ендон-Осорын Пэрэнгиймаа - Орхон аймгийн НААҮ-ний "Эрдэнэт ус, дулаан түгээх сүлжээ" ХК-ийн ҮЭ-ийн хорооны дарга

38. Жамъянгийн Ринчиндорж - Хэнтий аймгийн Биндэр сумын дунд сургуулийн математикийн багш

39. Цэндсүрэнгийн Сандуй - Нийслэлийн Газрын албаны газрын кадастрын хэлтсийн дарга

40. Хавдайн Смойль - Нийслэлийн барилга, сантехник угсралтын "Сэнх" ХХК-ийн тэргүүн дэд захирал

41. Тогтохын Соёлхүү - Нийслэлийн Газрын албаны мэргэжилтэн

42. Лхүндэвийн Сувдаа - Гаалийн ерөнхий газрын гаалийн улсын байцаагч

43. Хайсагийн Сыдх - Баян-Өлгий аймгийн Ногоонуур сумын ИТХ-ын ажилтан

44. Долгосүрэнгийн Сэржмядаг - МАХН-ын дэргэдэх нийгэм улс төр, судалгааны "Прогноз" төвийн номын сангийн ажилтан асан

45. Бат-Очирын Тогоохорол - Нийслэлийн МАХН-ын хорооны улс төрийн ажилтан

46. Чимэдцэрэнгийн Тогтохбаатар - Нийслэлийн хүнсний үйлдвэрлэлийн "Атар-Өргөө" ХК-ийн ерөнхий менежер

47. Гуудайн Төмөрчулуун - ГХЯ-ны Бодлого төлөвлөлт, мэдээлэл үнэлгээний газрын дэд захирал

48. Хожингийн Тунгаа - Нийслэлийн Чингэлтэй дүүргийн 10 жилийн 17 дугаар сургуулийн нийгмийн ажилтан

49. Шаахүүгийн Туяа - ГХЯ-ны Төрийн захиргааны удирдлагын газрын мэргэжилтэн

50. Данзангийн Удвал - Ховд аймгийн Дөргөн сумын ЗДТГ-ын дарга

51. Төмөрхүүгийн Хандсүрэн - Нийслэлийн барилгын үйлдвэрлэлийн "Анд интернэшл" ХХК-ийн захирал

52. Цэвэгмидийн Хорлообаатар - Улсын мэргэжлийн хяналтын газрын улсын ахлах байцаагч

53. Сэтэвийн Хулганаа - Нийслэлийн Хан-Уул дүүргийн тойргийн нотариатч

54. Хасбазарын Цэрмаа - Говь-Алтай аймгийн Есөнбулаг сумын "Жаргалант" багийн МАХН-ын үүрийн дарга

55. Базархүүгийн Цэрэндулам - Завхан аймгийн Дөрвөлжин сумын Засаг даргын орлогч бөгөөд төрийн сангийн төлөөлөгч

56. Балдангийн Цэцэгсүрэн - Улсын Нийгмийн даатгалын ерөнхий газрын захиргааны

хэлтсийн дарга

57. Нанзадын Чимэд - Сэлэнгэ аймгийн Хүдэр сумын Тарвагатайн 1 дүгээр багийн Засаг дарга

58. Өөдөсийн Чойжилсүрэн - Төв аймгийн Заамар сум дахь уул уурхайн "Шижир алт" ХХК-ийн алтны үйлдвэрийн драгийн техникийн удирдагч

59. Очирын Чулуунбат - Дундговь аймгийн Аудитын газрын ерөнхий аудитор

60. Намхайн Энхбаяр - Дорнод аймгийн Хөгжимт драмын театрын дарга

61. Сэр-Одын Энхтөр - Хэнтий аймгийн Бор-Өндөрийн уулын баяжуулах үйлдвэрийн далд нэвтрэлтийн бригадын дарга

62. Дэндэвийн Эрдэнэхүү - Булган аймгийн Хутаг-Өндөр сумын "Тээл" багийн малчин

63. Омбоосүрэнгийн Эрдэнэчимэг - Нийгэм, улс төрийн судалгааны "Прогноз" хүрээлэнгийн захирал, МАХН-ын улс төрийн хэлтсийн дарга

ЦЭРГИЙН ГАВЬЯНЫ ОДОНГООР:

Цэвээндоржийн Лувсан-Очир - Нийслэлийн Баянзүрх дүүрэг дэх Замын цагдаагийн тасгийн дарга, цагдаагийн дэд хурандаа

ХӨДӨЛМӨРИЙН ХҮНДЭТ МЕДАЛИАР:

1. Төмөрдаваагийн Алимаа - ШУА-ийн Физик технологийн хүрээлэнгийн эрдэм шинжилгээний туслах ажилтан

2. Лувсандашийн Амаржаргал - ТЗУААЭГ-ын харьяа Амралт, үйлчилгээний цогцолборын хүнсний нярав

3. Агваангонгорын Амарсайхан - Нийслэлийн Сүхбаатар дүүргийн Газрын албаны дарга

4. Жалбуугийн Бадамгарав - ШУА-ийн Геологи, эрдэс баялгийн хүрээлэнгийн секторын эрхлэгч

5. Рэнцэнгийн Байгалмаа - ШУА-ийн Хими, хими технологийн хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан

6. Намсрайжавын Батаа - Завхан аймгийн Түдэвтэй сумын ЗДТГ-т татварын улсын байцаагч

7. Бэгзийн Батсайхан - Архангай аймгийн зам засварын "АЗЗА-Архангай" ХХК-ийн жолооч

8. Сосорбарамын Баттулга - Төв аймгийн Заамар сум дахь уул уурхайн "Шижир алт" ХХК-ийн алтны үйлдвэрийн бульдозерийн машинч

9. Банзрагчийн Батцэнгэл - Нийслэлийн хөнгөн атлетийн "MN-Атлетик" клубын дэд тэргүүн

10. Батсуурийн Батцэцэг - Сангийн яамны Төрийн сангийн газрын санхүүжилт, тайлан бүртгэлийн хэлтсийн дарга

11. Эрдэнэ-Очирын Бат-Эрдэнэ - Улсын мэргэжлийн хяналтын газрын улсын ахлах байцаагч

12. Дугарсүрэнгийн Баярсайхан - Нийслэлийн Налайх дүүргийн "Налайхын дулааны станц" ХК-ийн машинист

13. Батчулууны Баясгалан - Архангай аймгийн зам засварын "АЗЗА- Архангай" ХХК-ийн ерөнхий инженер

14. Рэгээдмаагийн Болд - Булган аймгийн Орон нутгийг судлах музейн сан хөмрөгч, эрдэм шинжилгээний ажилтан

15. Чанцалын Бямбадаш - Улсын Нийгмийн даатгалын ерөнхий газрын даатгалын мэргэжилтэн

17. Банзрагчийн Галбадрах - Иргэний бүртгэл, мэдээллийн улсын төвийн хяналтын улсын байцаагч

18. Дашзэвгийн Ганболд - Сүхбаатар аймгийн Баруун-Урт сум дахь Талбулагийн нүүрсний уурхайн "Талын гал" ХК-ийн гагнуурчин

19. Жансэдийн Гантөмөр - Улсын мэргэжлийн хяналтын газрын албаны орлогч дарга

20. Оргойн Даваа - Дорноговь аймгийн Нэгдсэн эмнэлгийн мэдрэлийн их эмч

21. Бандын Дамдингарав - Дорноговь аймгийн Нэгдсэн эмнэлгийн халдварт, сүрьеэгийн тасгийн сувиллагч

22. Жийяны Дуламсүрэн - Нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн 10 жилийн 62 дугаар сургуулийн монгол хэл, уран зохиолын багш

23. Дүгэржавын Дүнчигмаа - МАХН-ын дэргэдэх нийгэм улс төр, судалгааны "Прогноз" хүрээлэнгийн номын сангийн фондын эрхлэгч

24. Далайн Дэнсмаа - ШУА-ийн Хими, хими технологийн хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан

25. Сономын Зүмбэрэл - Орхон аймгийн Нэгдсэн эмнэлгийн мэс заслын их эмч

26. Лувсаншаравын Лхагвасүрэн - Улсын мэргэжлийн хяналтын газрын улсын ахлах байцаагч

27. Дэчингийн Мөнгөншагай - Улсын Нийгмийн даатгалын ерөнхий газрын даатгалын мэргэжилтэн

28. Юндэнгийн Нэргүй - Нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн 10 жилийн 62 дугаар сургуулийн бага ангийн багш

29. Болдын Нямзаа - Монгол Сингапурын хамтарсан хөрөнгө оруулалттай гэрэл зургийн "Жи-Эй-Жи" ХХК-ийн дэд захирал, ерөнхий нягтлан бодогч

30. Чойдонгийн Орлом - Гэмтэл согог сэргээн засалтын клиникийн тархи, нуруу нугасны тасгийн их эмч

31. Эрдэнэгаравын Отгонлхагва - Нийслэлийн худалдаа, үйлчилгээний "Дүүхээ" ХХК-ийн нярав

32. Жамсрангийн Оюунцэцэг - ГХЯ-ны

Дипломат байгууллагын үйлчилгээ, аж ахуйн газрын нярав-тогоч

33. Дагвадоржийн Пүрэвдорж - ГХЯ-ны Дипломат байгууллагын үйлчилгээ, аж ахуйн газрын жолооч

34. Хандсүрэнгийн Пүрэвсүрэн - Сангийн яамны Төрийн сангийн газрын дарга

35. Содномын Санжжав - ШУА-ийн Одон орон, геофизикийн судалгааны төвийн эрдэм шинжилгээний ажилтан

36. Лувсандоржийн Санжид - Нийгмийн Эрүүл мэндийн хүрээлэнгийн дэд захирал

37. Галсанжавын Сарантуяа - Орхон аймгийн эрүүл мэндийн "Донаса" өрхийн эмнэлгийн өрхийн эмч

38. Дарамжавын Солонго - Нийслэлийн хууль зүйн зөвлөгөө өгөх "Аделтус консалтинг фирм" ХХК-ийн захирал, Баянгол дүүргийн тойргийн нотариатч

39. Ядамцоогийн Сувдмаа - Говь-Алтай аймгийн Мэргэжлийн хяналтын газрын хяналтын улсын байцаагч

40. Гэндэнгийн Сүхбаатар - Хэнтий аймгийн Биндэр сумын "Мандалхаан" багийн малчин

41. Лодонгийн Сэлэнгэ - ШУА-ийн Одон орон, геофизикийн судалгааны төвийн эрдэм шинжилгээний ажилтан

42. Гунгаагийн Тогоохүү - Төв аймгийн Эрдэнэ сум дахь "Ар жанчивлан" рашаан сувилалын аж ахуй эрхэлсэн орлогч дарга

43. Халтарын Тунгалагтуяа - Нийслэлийн Сүхбаатар дүүргийн Татварын хэлтсийн татварын улсын байцаагч

44. Жигмэддоржийн Үүрцайх - Сангийн яамны харьяа Сорьцын улсын хяналтын албаны химич

45. Моломын Хишигт - ШУА-ийн Физик технологийн хүрээлэнгийн эрдэм шинжилгээний туслах ажилтан

46. Өлзийхутагийн Хонгорзул - Сүхбаатар аймгийн Баруун-Урт сумын ИТХТ-ийн дарга

47. Гомбын Цогтсайхан - Дундговь аймгийн Засаг даргын Тамгын газрын мэргэжилтэн

48. Дэмчигжавын Цэнд - ГХЯ-ны Дипломат байгууллагын үйлчилгээ, аж ахуйн газрын автогараашийн дарга

49. Ганбаатарын Цэндсүрэн - Улсын мэргэжлийн хяналтын газрын улсын ахлах байцаагч

50. Намнангийн Цэцэгмаа - Орхон аймгийн Баян-Өндөр сумын "Наран" цогцолбор сургуулийн түүхийн багш

51. Ханджавын Цэцэгмаа - Гэмтэл согоо сэргээн засалтын клиникийн Түлэнхийн төвийн хагалгааны тасгийн сувилагч

52. Мишигийн Чулуунбат - Дархан-Уул аймгийн Дархан сумын 15 дугаар багийн олон нийтийн байцаагч

53. Ёндонгийн Энхцэцэг - Орхон аймгийн Хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах нийгэмлэгийн дарга

54. Даваажавын Эрдэнэцогт - Архангай аймгийн ЗДТГ-ын байгаль орчны бодлого хариуцсан түшмэл

55. Дагвын Эрдэнэчимэг - Иргэний бүртгэл, мэдээллийн улсын төвийн архивын эрхлэгч

56. Лувсандамдины Эрдэнэчимэг - Нийслэлийн Мал эмнэлэг үржлийн газрын малын эмийн эм зүйч

57. Батбаярын Янжинлхам - Архангай аймгийн Нэгдсэн эмнэлгийн хүүхдийн тасгийн сувилагч

ЦЭРГИЙН ХҮНДЭТ МЕДАЛИАР:

1. Сүрэнжавын Даваацэрэн - Нийслэлийн Сонгинохайрхан дүүрэг дэх Замын цагдаагийн тасгийн дарга, цагдаагийн дэд хурандаа

дүүрэг дэх Замын цагдаагийн тасгийн зохицуулагч цагдаа, цагдаагийн ахлах ахлагч

2. Ягаадайн Рэнцэн - Нийслэлийн Хан-Уул

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ

Н.ЭНХБАЯР

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2005 оны 12 дугаар сарын 30-ны өдөр

Дугаар 143

Улаанбаатар хот

Шүүхийн сахилгын хорооны бүрэлдэхүүнийг батлах тухай

"Шүүхийн тухай" Монгол Улсын хуулийн 46 дугаар зүйлийн 4 дэх заалтыг баримтлан ЗАРЛИГ

Шүүхийн сахилгын хорооны бүрэлдэхүүнийг хавсралт ёсоор баталсугай.

БОЛГОХ нь:

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ

Н.ЭНХБАЯР

**Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2005 оны
143 дугаар зарлигийн хавсралт**

1. Д.Батсайхан - Улсын дээд шүүхийн шүүгч, Эрүүгийн хэргийн танхимын тэргүүн
2. П.Атарцэцэг - Улсын дээд шүүхийн шүүгч
3. Ё.Бямбацэрэн - Булган аймгийн шүүхийн ерөнхий шүүгч
4. Г.Лхагвамаа - Говьсүмбэр аймгийн шүүхийн ерөнхий шүүгч
5. А.Отгонцэцэг - Нийслэлийн Захиргааны хэргийн шүүхийн шүүгч
6. Б.Баатар - Нийслэлийн Хан-Уул дүүргийн шүүхийн ерөнхий шүүгч
7. Ж.Оюунчимэг - Улсын ерөнхий прокурорын газрын Бодлого төлөвлөлт, гадаад харилцааны хэлтсийн дарга
8. С.Баттөмөр - Улсын ерөнхий прокурорын газрын Хэрэг эрхлэх газрын дарга

9. Б.Энхзаяа - Нийслэлийн Өмгөөлөгчдийн зөвлөлийн дарга
10. Д.Намсрайжав - Монголын Өмгөөлөгчдийн холбооны гишүүн, өмгөөлөгч
11. Н.Лүндэндорж - МУИС-ийн Хууль зүйн дээд сургуулийн дэд захирал, доктор, профессор
12. Ж.Бямбаа - МУИС-ийн Хууль зүйн дээд сургуулийн Эрүүгийн танхимын эрхлэгч, доктор, профессор
13. С.Баярмөнх - Нийслэлийн ИТХ-ын тэргүүлэгч, ГХЯ-ны харьяа Дипломат байгууллагын үйлчилгээ, аж ахуйн газрын дарга
14. И.Цэрэндулам - Нийслэлийн Засаг даргын хуулийн зөвлөх
15. С.Айнагуль - Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хууль зүйн хэлтсийн ахлах зохион байгуулагч

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2005 оны 10 дугаар сарын 12-ны өдөр

Дугаар 215

Улаанбаатар хот

**Үндэсний хөтөлбөр (журам)
батлах тухай**

Олон улсын иргэний нисэхийн тухай конвенцийн 17 дугаар хавсралт, Иргэний нисэхийн тухай хуулийн 6.1.4-т заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

бүрэлдэхүүнийг батлах тухай" Засгийн газрын 1999 оны 5 дугаар сарын 19-ний өдрийн 79 дүгээр тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

1. Иргэний нисэхийн аюулгүй байдлын үндэсний хөтөлбөрийг хавсралт ёсоор баталсугай.
2. Энэ тогтоол гарсантай холбогдуулан "Журам (хөтөлбөр), дүрэм, Зөвлөлийн

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД**

Ц.ЭЛБЭГДОРЖ

**ЗАМ, ТЭЭВЭР, АЯЛАЛ
ЖУУЛЧЛАЛЫН САЙД**

Г.БАТХҮҮ

**Засгийн газрын 2005 оны 215 дугаар
тогтоолын хавсралт**

**ИРГЭНИЙ НИСЭХИЙН АЮУЛГҮЙ БАЙДЛЫН
ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨР**

Нэг. Нийтлэг үндэслэл

ажиллагааг зохион байгуулах, хэрэгжүүлэхэд чиглэгдэнэ.

1.1. Нисэхийн аюулгүй байдлын дүрэм, журмыг хэрэгжүүлэх замаар иргэний нисэхийн үйл ажиллагааг хөндлөнгийн хууль бус үйлдлээс хамгаалахад Иргэний нисэхийн аюулгүй байдлын үндэсний хөтөлбөр (цаашид Хөтөлбөр гэнэ)-ийн зорилго оршино.

1.3. Иргэний нисэхийн аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааны үндсэн зорилго нь зорчигч, агаарын хөлгийн багийн гишүүн, газрын үйлчилгээ болон хилийн хяналтын байгууллагын ажилтнууд, иргэд, түүнчлэн агаарын хөлөг, нисэх буудлын байгууламж, тоног төхөөрөмжийг газарт болон агаарт тохиолдож болох хөндлөнгийн хууль бус үйлдлээс хамгаалахад оршино.

1.2. Хөтөлбөр нь дотоодын болон гадаадын агаарын тээвэрлэгч, Монгол Улсын нутаг дэвсгэрт байгаа нисэх буудлын аюулгүй байдлыг хангах үйл

1.4. Энэ хөтөлбөрт хэрэглэсэн нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно:

1.4.1. "хөндлөнгийн хууль бус үйлдэл" гэж иргэний нисэхийн болон агаарын тээврийн аюулгүй байдалд нөлөөлөх дараахь үйлдэл, эсхүл оролдлогыг:

-нислэг үйлдэж буй болон газарт байгаа агаарын хөлгийг булаан эзлэх;

-агаарын хөлөг болон нисэх буудалд хүн барьцаалах;

-агаарын хөлөг, нисэх буудлын хамгаалагдсан бус болон агаарын навигацгийн тоног төхөөрөмжид зөвшөөрөлгүйгээр хүч түрэмгийлэн нэвтрэх;

-гэмт хэрэг үйлдэх зорилгоор агаарын хөлөг, нисэх буудалд зэвсэг, аюултай бодис болон эд зүйлсийг нэвтрүүлэх;

-нислэг үйлдэж буй болон газарт байгаа агаарын хөлөг, зорчигч, агаарын хөлгийн нисэх багийн гишүүд, нисэх буудлын газрын үйлчилгээний ажилтан, иргэдийн аюулгүй байдал, иргэний нисэхийн үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлж болзошгүй хуурамч мэдээ, мэдээллийг тараах.

1.4.2. "аюулгүй байдлын үзэл" гэж хөндлөнгийн хууль бус үйлдэлд ашиглаж болзошгүй зэвсэг, тэсэрч дэлбэрэх зүйл, аюултай ачааг илрүүлэх зорилгоор хүний бие, гар тээш, тээш, ачаанд хийх үзлэгийг;

1.4.3. "агаарын хөлгийн аюулгүй байдлын үзэл" гэж зэвсэг, тэсрэх бодис болон агаараар тээвэрлэхэд аюултай бусад зүйлийг илрүүлэх зорилгоор нислэгийн өмнө агаарын хөлөгт хийх үзлэгийг;

1.4.4. "хилийн бүс" гэж агаарын харилцааны олон улсын боомтод хилийн хяналтын байгууллагууд хяналт, шалгалт явуулах зорилгоор тусгай журам тогтоосон нисэх буудлын барилга байгууламжийн хэсгийг;

1.4.5. "хамгаалагдсан бүс" гэж тухайн нисэх буудлын аюулгүй байдлын хөтөлбөрт хамгаалагдсан бүс гэж тодорхойлсон нисэх буудал, аэродромын хэсгийг;

1.4.6. "нийтийн эзэмшлийн бүс" гэж ямар нэг зөвшөөрөлгүйгээр чөлөөтэй орж гарч болох нисэх буудлын барилга байгууламж, түүний орчны хэсгийг;

1.4.7. "үзлэгийн дараахь бүс" гэж аюулгүй байдлын үзлэгт орсон зорчигчдыг агаарын хөлөгт суулгахаас өмнө хүлээлгэх зориулалт бүхий нисэх буудлын хэсгийг;

1.4.8. "тусгай арга хэмжээ" гэж иргэний нисэхийн аюулгүй байдлын үйл ажиллагааны стандартад тусгагдаагүй, нисэхийн аюулгүй байдлыг хангахад чиглэсэн, эрх бүхий байгууллагуудын оролцоотой хэрэгжүүлэх арга хэмжээ, ажиллагааг;

1.4.9. "агаарын хөлгийн зогсоол" гэж агаарын хөлгийг байрлуулахад зориулагдсан перроны хэсэг, талбайг;

1.4.10. "ачаа" гэж агаарын хөлгөөр тээвэрлэж байгаа тээш, шуудангаас бусад эд зүйлсийг;

1.4.11. "тээш" гэж агаарын хөлгийн зорчигчийн хувийн эд зүйлсийг;

1.4.12. "бүртгэгдсэн тээш" гэж агаарын хөлгийн зорчигчийн агаарын тээвэрлэгчийн хариуцлагад хүлээлгэн өгч тээшний тасалбар буюу зүүлт олгосон эд зүйлсийг;

1.4.13. "гар тээш" гэж зорчигч өөрөө хариуцан биедээ авч явахыг зөвшөөрсөн эд зүйлсийг;

1.4.14. "эзэнгүй тээш" гэж тээшний зүүлттэй буюу зүүлтгүй, эзэн нь тогтоогдоогүй тээшийг;

1.4.15. "дамжин өнгөрөх зорчигч" гэж тухайн аяллын завсрын нисэх буудалд ирсэн агаарын хөлгөөрөө нислэгээ цааш үргэлжлүүлж байгаа зорчигчийг;

1.4.16. "шилжин суух зорчигч" гэж тээвэрлэлтийн гэрээний дагуу нислэгээ үргэлжлүүлэхийн тулд нэг агаарын хөлгөөс нөгөө агаарын хөлөгт шилжин сууж байгаа зорчигчийг;

1.4.17. "метал илрүүлэгч" гэж хүний биедээ авч яваа металл эдлэлийг илрүүлэхэд ашиглах төхөөрөмжийг;

1.4.18. "сэжигтэй зүйл" гэж агаарын хөлгөөр тээвэрлэхийг хориглосон, эсхүл хязгаарласан биет зүйл болон бодис агуулсан байж болох магадлал ихтэй гэж тодорхойлсон зүйлийг;

1.5. Энэ хөтөлбөрт хамаарах Монгол Улсын олон улсын гэрээ, конвенц:

- "Олон улсын иргэний нисэхийн тухай" 1944 оны Чикагогийн конвенц;

- "Агаарын хөлөгт гарсан гэмт халдлага болон зарим онцгой хэргийн тухай" 1963 оны Токиогийн конвенц;

"Агаарын хөлгийг хууль бусаар булаан авахтай тэмцэх тухай" 1970 оны Гаагийн конвенц;

"Иргэний нисэхийн аюулгүй байдлын эсрэг хууль бус үйлдэл гаргуулахгүй байх тухай" 1971 оны Монреалийн конвенц;

"Хуванцар тэсрэх бодис илрүүлэх зорилгоор тэмдэглэл хийх тухай" 1999 оны Монреалийн конвенц;

"Олон улсын иргэний нисэхэд үйлчилж буй нисэх буудалд хүчирхийллийн хууль бус үйлдэлтэй тэмцэх тухай" 1999 оны Монреалийн протокол.

Энэ хөтөлбөрт хамаарах үндэсний эрх зүйн баримт бичиг:

- Монгол Улсын Үндсэн хууль;
- Иргэний нисэхийн тухай хууль;
- Галт зэвсгийн тухай хууль;
- Гэрээт харуул хамгаалалтын тухай хууль;
- Захиргааны хариуцлагын тухай хууль;
- Терроризмтэй тэмцэх тухай хууль;
- Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн эргэлтэд хяналт тавих тухай хууль;
- Төрийн тусгай хамгаалалтын тухай хууль;
- Хилийн тухай хууль;
- Эрүүгийн хууль;
- Иргэний нисэхийн багц дүрэм (цаашид ИНД гэх), тэдгээрийн зөвлөмжийн цувралууд;
- бусад.

Хоёр. Иргэний нисэхийн аюулгүй байдлын талаар иргэний нисэхийн болон бусад байгууллагын хүлээх үүрэг

2.1. Иргэний нисэхийн аюулгүй байдлын зөвлөл (цаашид "Зөвлөл" гэх) нь иргэний нисэхийн аюулгүй байдлыг хангах, түүнийг хөндлөнгийн хууль бус үйлдлээс хамгаалах эрх бүхий байгууллагуудын үйл ажиллагааг үндэсний хэмжээнд уялдуулан зохицуулна. Зөвлөл нь дараахь бүрэн эрхтэй:

2.1.1. агаарын хөлгийг булаан авах, авч зугтаах болон иргэний нисэхийн үйл ажиллагаатай холбогдсон хөндлөнгийн аливаа хууль бус үйлдлийн үед бий болсон онцгой нөхцөл байдлыг зохицуулах, шийдвэр гаргах;

2.1.2. барьцаалах замаар агаарын хөлгийг булаан авах, авч зугтаах тохиолдолд нисэх буудлын аюулгүй байдлын хорооны үйл ажиллагааг удирдах;

2.1.3. иргэний нисэхийн аюулгүй байдлыг хангуулах асуудлаар Иргэний нисэхийн

ерөнхий газарт зөвлөлгөө өгөх, туслалцаа үзүүлэх;

2.1.4. иргэний нисэхийн аюулгүй байдлыг хангах арга хэмжээний хэрэгжилтэд хяналт тавих;

2.1.5. иргэний нисэхийг хөндлөнгийн хууль бус үйлдлээс хамгаалах тогтолцооны үзэл баримтлалыг боловсруулах;

2.1.6. иргэний нисэхийг хөндлөнгийн хууль бус үйлдлээс хамгаалах тогтолцоог боловсронгуй болгох талаар санал боловсруулж эрх бүхий байгууллагад оруулах;

2.1.7. иргэний нисэхийн үйл ажиллагаанд гарч болзошгүй хөндлөнгийн хууль бус үйлдлээс урьдчилан сэргийлэх, тэдгээрийг таслан зогсоох, түүний хор уршгийг арилгахад иргэний нисэхийн байгууллага, аж ахуйн нэгжийн хүч, хэрэгслийг татан оролцуулах, иргэний нисэхийн болон бусад байгууллага, аж ахуйн нэгжийн үйл ажиллагааны уялдааг хангах;

2.1.8. иргэний нисэхийн эсрэг заналхийллийн түвшинг жил бүр тогтоож, энэхүү заналхийллийн түвшинд нийцсэн нисэхийн аюулгүй байдлын арга хэмжээний төлөвлөгөө гаргаж, хэрэгжилтэд хяналт тавих.

2.1.9. үйл ажиллагааны тайланг жил бүрийн 2 дугаар сард багтаан Засгийн газарт танилцуулах.

2.2. Иргэний нисэхийн ерөнхий газар (цаашид Ерөнхий газар гэх) нь үйл ажиллагаагаа Иргэний нисэхийн тухай хуулийн 8.2-т заасны дагуу иргэний нисэхийн аюулгүй байдлыг хангуулахад чиглүүлдэг. Ерөнхий газар нь дараахь үүрэгтэй:

2.2.1. иргэний нисэхийн аюулгүй байдлын хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга замыг тодорхойлох, оролцогч байгууллагуудын үүргийг хуваарилан уялдуулан зохицуулах;

2.2.2. нисэх буудлын хамгаалагдсан бүсэд нэвтрэх журмыг баталж хэрэгжилтэд хяналт тавих;

2.2.3. нисэх буудал, агаарын тээвэрлэгч, ачаа, шуудан тээвэр, нислэгийн хоол хүнс бэлтгэх байгууллагуудын аюулгүй байдлын хөтөлбөр, түүнд оруулсан өөрчлөлтийг хянаж баталгаажуулах;

2.2.4. гадаад улсаас Монгол Улсад нислэг үйлдэж байгаа агаарын тээвэрлэгчийн аюулгүй байдлын хөтөлбөр, түүнд оруулсан өөрчлөлтийг хянаж, хүлээн зөвшөөрөх;

2.2.5. иргэний нисэхийн аюулгүй байдлын стандарт, дүрэм, журмыг боловсруулах, дагаж мөрдүүлэх;

2.2.6. иргэний нисэхийн аюулгүй байдлын үйлчилгээ эрхлэх байгууллагад гэрчилгээ олгох;

2.2.7. иргэний нисэхийн аюулгүй байдлын сургалтын хөтөлбөрийг боловсруулж, аюулгүй байдлын сургалт явуулах байгууллагад гэрчилгээ олгох;

2.2.8. нисэх буудлын хилийн бүсэд нэвтрэх журмыг хил хамгаалах байгууллагатай хамтран тогтоох;

2.2.9. хөндлөнгийн хууль бус үйлдлийн дараа авсан арга хэмжээ болон үйл ажиллагаанд үнэлэлт өгч, дахин давтагдахаас урьдчилан сэргийлэх арга хэмжээ авч, Олон улсын иргэний нисэхийн байгууллагад мэдэгдэх.

2.3. Нисэх буудал нь агаарын тээврээр зорчигчдын аюулгүй байдлыг хангасан орчинг бүрдүүлнэ. Нисэх буудал нь дараахь үүрэгтэй:

2.3.1. нисэх буудлын удирдлага нь нисэх буудлыг хөндлөнгийн хууль бус үйлдлээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн, ИНД-139-д заасан стандарт, шаардлагын дагуу авч хэрэгжүүлэх;

2.3.2. Хөтөлбөр болон хууль тогтоомжид нийцүүлэн гаргасан стандарт, дүрэм, журам, заавар болон тухайн нисэх буудлын үйл ажиллагааны онцлогт нийцсэн нисэх буудлын аюулгүй байдлын хөтөлбөрийг боловсруулан хэрэгжүүлэх;

2.3.3. өргөтгөлийн ажил хийх, тоног төхөөрөмж шинээр байрлуулах, суурилуулах ажлыг аюулгүй байдлыг хангах үйл ажиллагаанд саад учруулахгүйгээр зөвхөн Ерөнхий газрын шийдвэрээр гүйцэтгэх;

2.3.4. хөндлөнгийн хууль бус үйлдлийн үед авч хэрэгжүүлэх арга хэмжээний зааварчилгааг багтаасан онцгой байдлын үед ажиллах журам боловсруулан хэрэгжүүлэх. Онцгой байдлын үед ажиллах журамд дараахь үйл ажиллагааны зааварчилгааг тусгана:

а/ агаарын хөлгийг булаах, авч зугтаах, хүн барьцаалах, нисэх буудалд болон нисэх буудлын бүсэд хорлон сүйтгэх ажиллагаа явуулахаар заналхийлэх;

б/ нисэх буудалд болон түүний орчимд эмх замбараагүй байдал үүсэх;

в/ агаарын хөлгөөс зорчигчдыг нүүлгэн шилжүүлэх, агаарын хөлөгт үзлэг хийх;

г/ нисэхийн аюулгүй байдлын өндөржүүлсэн бэлэн байдлын үед болон заналхийллийн түвшин өндөртэй нислэгт аюулгүй байдлын тусгай арга хэмжээ авах.

2.4. Олон улсын нисэх буудал нь дараахь үүрэгтэй:

2.4.1. нисэх буудлын аюулгүй байдлын хөтөлбөрийн хэрэгжилтийг хариуцсан аюулгүй байдлын албан тушаалтныг томилох;

2.4.2. нисэх буудлын аюулгүй байдлын хороо байгуулах.

2.5. Агаарын тээвэрлэгч нь өөрийн үйл ажиллагааг нисэхийн аюулгүй байдлыг хангасан нөхцөлд явуулна. Агаарын тээвэрлэгч нь дараахь үүрэгтэй:

2.5.1. зорчигч, агаарын хөлөг болон тээш, ачаа, шуудан хадгалах талбайн аюулгүй байдлыг хангах, эсхүл энэхүү үүргийг гэрээний үндсэн дээр мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлэх;

2.5.2. энэхүү хөтөлбөрийн шаардлагад нийцсэн, хөндлөнгийн хууль бус үйлдлээс хамгаалах зааварчилгааг багтаасан аюулгүй байдлын хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлэх;

2.5.3. агаарын тээвэрлэгчийн аюулгүй байдлын хөтөлбөрт хөтөлбөрийн зорилго, хэрэгжилтийг хариуцах албан тушаалтан, нэгж, тэдгээрийн хүлээх үүрэг, хариуцлагыг тодорхойлж, аюулгүй байдлыг хангахад чиглэсэн дараахь арга хэмжээг тусгана:

а/ нислэгийн өмнө агаарын хөлөгт аюулгүй байдлын үзлэг хийх;

б/ зорчигч болон түүний гар тээш, тээш, ачаанд аюулгүй байдлын үзлэг хийх;

в/ нислэгийн үед агаарын хөлгийн нисэгчийн бүхээгт зөвшөөрөлгүй этгээд нэвтрэн орохоос урьдчилан сэргийлэх;

г/ дамжин өнгөрөх нисэх буудалд агаарын хөлгөөс зорчигчдыг буулгасны дараа агаарын хөлөгт аюулгүй байдлын үзлэг хийх;

д/ зөвхөн тухайн агаарын хөлгөөр зорчих зорчигчийн бүртгүүлсэн тээшийг тээвэрлэх;

е/ бүртгэгдсэн тээш, ачаа, шуудан болон нислэгийн хоол хүнс, агаарын хөлгийн хангамжийн эд зүйлийн аюулгүй байдлыг хангах;

ж/ хууль хяналтын байгууллагын хяналтад байгаа этгээдийг тээвэрлэх;

з/ агаарын хөлөгт зэвсэг тээвэрлэх;

и/ зогсоолд байгаа агаарын хөлгийн аюулгүй байдлыг хангах, хамгаалалтад авах, нэвтрэх.

2.6. Иргэний нисэхийн аюулгүй байдлын үйлчилгээ эрхлэх байгууллага нь ИНД-140-ийн дагуу гэрчилгээ авсан байна. Иргэний нисэхийн аюулгүй байдлын үйлчилгээ эрхлэх байгууллага нь дараахь үүрэгтэй:

2.6.1. ажилтнуудаа иргэний нисэхийн аюулгүй байдлын сургалтын хөтөлбөр, стандартын дагуу сургаж, дадлагажуулах;

2.6.2. аюулгүй байдлын үзлэгийг зөвхөн эрх бүхий этгээдээр гүйцэтгүүлэх;

2.6.3. нисэхийн аюулгүй байдлын дүрэм, журамд нийцсэн үйлчилгээ үзүүлэх.

2.7. Цагдаагийн байгууллага нь иргэний нисэхийн аюулгүй байдлыг хангах, хөндлөнгийн хууль бус үйлдлээс урьдчилан сэргийлэх ажлыг иргэний нисэхийн байгууллагатай хамтран зохион байгуулна. Цагдаагийн байгууллага нь дараахь үүрэгтэй:

2.7.1. иргэний нисэхийн байгууламжид гэмт хэрэгтэй тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх, нийгмийн хэв журам сахиулах;

2.7.2. хөндлөнгийн хууль бус үйлдлээс урьдчилан сэргийлэх, агаарын хөлгийг хууль бусаар булаан авах, хорлон сүйтгэх ажиллагаа явуулах, тэсрэх бодис хэрэглэхээр сүрдүүлэх, нисэх буудал болон түүний байгууламжид халдах, нийтийн эмх замбараагүй байдал үүссэн үед авах арга хэмжээ, ажиллагааг нисэх буудлын онцгой байдлын үед ажиллах журамд тусган хэрэгжүүлэх;

2.7.3. цагдаагийн алба хаагчдыг нисэхийн аюулгүй байдлын сургалтад хамруулах.

2.8. Нислэгийн хоол хүнс бэлтгэх байгууллага нь хоол хүнс болон агаарын хөлгийн хангалтад хэрэглэх эд зүйлд зэвсэг, тэсэрч дэлбэрэх бодис болон бусад аюултай зүйлийг нүүн нэвтрүүлэхээс урьдчилан сэргийлэх талаар

аюулгүй байдлын хөтөлбөртөө тусган хэрэгжүүлнэ.

2.9. Хил хамгаалах болон хилийн хяналтын байгууллага, нисэх буудалд түрээсийн гэрээний дагуу үйл ажиллагаа эрхэлж байгаа байгууллага нь ажилтнаа нисэхийн аюулгүй байдлын холбогдох сургалтад хамруулах, хамгаалагдсан болон үзлэгийн дараахь бүсэд нэвтрэх журмыг биелүүлэх үүрэгтэй.

2.10. Хил хамгаалах болон хилийн хяналтын байгууллага, нисэх буудалд үйл ажиллагаа эрхэлж байгаа байгууллагууд нь иргэний нисэхийн аюулгүй байдлыг хангах ажиллагааг бодитой, үр дүнтэй хэрэгжүүлэх нөхцөлийг бүрдүүлэх, нисэхийн аюулгүй байдлыг хангах хариуцлага хүлээсэн байгууллагын үйл ажиллагаанд нь дэмжлэг үзүүлэх чиглэлээр хамтарч ажиллана.

Гурав. Нисэхийн аюулгүй байдлын үйл ажиллагааны зохицуулалт

3.1. Монгол Улсын болон гадаад улсын Засгийн газар хоорондын Агаарын харилцааны тухай хэлэлцээрт иргэний нисэхийн аюулгүй байдлыг хангах талаар холбогдох заалтыг тусгасан байна.

3.2. Иргэний нисэхийн аюулгүй байдлын зөвлөлийн дарга нь иргэний нисэхийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн байна. Зөвлөлийн дарга нь зөвлөлийн бүрэлдэхүүнийг томилно.

3.3. Зөвлөл нь иргэний нисэхийн аюулгүй байдлын асуудал эрхэлсэн эрх бүхий байгууллагын талаар Олон улсын иргэний нисэхийн байгууллагад мэдэгдэнэ.

3.4. Иргэний нисэхийн аюулгүй байдлыг хангах талаар гаргасан зөвлөлийн шийдвэрийг төв, орон нутгийн төрийн захиргааны бүх шатны болон аж ахуйн нэгж, байгууллага, албан тушаалтан, иргэн заавал биелүүлнэ.

3.5. Хэвлэл, мэдээллийн байгууллага нь хөндлөнгийн хууль бус үйлдэлтэй холбоотой болон нисэхийн аюулгүй байдлыг хангахтай холбоотой аливаа мэдээллийг Ерөнхий газраас томилогдсон төлөөлөгчөөр дамжуулан авна.

3.6. Энэхүү хөтөлбөрийг аль нэг улсын хүсэлтийн дагуу тухайн улсад танилцуулж болох бөгөөд олон улсын иргэний нисэхийн аюулгүй байдлын түвшинг дээшлүүлэх зорилгоор бусад улстай туршлага солилцож, хамтран ажиллана.

3.7. Ерөнхий газар нь аль нэг улсын хүсэлтээр тухайн улсын агаарын тээвэрлэгчийн

гүйцэтгэж байгаа тодорхой чиглэлийн нислэгийн аюулгүй байдлыг хангахтай холбогдсон арга хэмжээ авч болно.

3.8. Ерөнхий газар нь аль нэг улсын иргэний нисэхийн үйл ажиллагаанд аюул заналхийлж байгаа талаар олж авсан мэдээллийг зөвлөлд болон тухайн улсын эрх бүхий байгууллагад мэдэгдэнэ.

3.9. Ерөнхий газар болон холбогдох сургалтын байгууллага нь аюулгүй байдлын ажилтныг иргэний нисэхийн аюулгүй байдлын сургалтын хөтөлбөрийн дагуу сургаж, дадлагажуулах, ур чадварыг нь дээшлүүлэх, энэ чиглэлээр гадаад оронтой хамтран ажиллана.

3.10. Нууцын зэрэглэлтэй мэдээ мэдээллийг хамгаалах, хадгалах талаар тагнуулын болон цагдаагийн байгууллагатай хамтран ажиллана.

3.11. Зөвлөл нь агаарын хөлгийн зорчигчийн бүхээгт аюулгүй байдлын ажилтан ажиллуулах талаар гадаад дотоодын агаарын тээвэрлэгчээс ирүүлсэн хүсэлтийг хүлээн авч шийдвэрлэнэ.

Дөрөв. Нисэх буудал, агаарын хөлөг, агаарын навигацийн тоног төхөөрөмжийн хамгаалалт

4.1. Ерөнхий газар нь нисэх буудлын захиргаа болон холбогдох бусад байгууллагатай хамтарч тухайн нисэх буудлын хамгаалгдсан бүсийг тогтоож, бүдүүвч зургийг батална.

4.2. Нисэх буудлын гадна орших хамгаалагдсан бүсэд дараахь тоног төхөөрөмжийг байрлуулсан талбай багтана:

4.2.1. радиолокатор;

4.2.2. агаарын навигацийн хэрэгслүүд (ILS-хэрэглэлийн суултын систем, VOR-DME, NDB-чиглүүлэх станц);

4.2.3. VHF - хэт богино давтамжийн холбооны станц, антен;

4.2.4. УКВ-алсын удирдлагатай хэт богино давтамжийн станц;

4.2.5. бусад шаардлагатай тоног төхөөрөмж, объект.

4.3. Нисэх буудлын гадна орших хамгаалагдсан бүсэд байгаа агаарын навигацийн тоног төхөөрөмж болон барилга байгууламжийн хамгаалалтыг нисэх буудлын захиргаа хариуцна.

4.4. Хамгаалагдсан бүсийн аюулгүй байдлыг хашаа хамгаалалт байгуулах, дохиолол, гэрэлтүүлэг болон камерын хяналтын систем суурилуулах, харуул хамгаалалтын ажилтан томилох замаар хангана.

4.5. Хамгаалагдсан бүс нь нийтийн эзэмшлийн бүсээс тусгаарлагдсан байх бөгөөд түүний аюулгүй байдал зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг нисэх буудлын аюулгүй байдлын хөтөлбөрт тусгаж хэрэгжүүлнэ.

4.6. Хамгаалагдсан бүсэд тээврийн хэрэгсэл, хүмүүсийг нэвтрүүлэхдээ аюулгүй байдлын үзлэг хийнэ.

4.7. Ерөнхий газар нь хамгаалагдсан бүсэд нэвтрэх үнэмлэх олгох эрх бүхий байгууллагыг тогтооно.

4.8. Хамгаалагдсан бүсэд нэвтрүүлэхэд агаарын хөлгийн зорчигч иргэний үнэмлэх, эсхүл гадаад паспорт, нислэгийн тийз болон суугчийн тасалбар, бусад хүмүүс нэвтрэх үнэмлэх үзүүлнэ.

4.9. Хамгаалагдсан бүсэд нэвтрэх үнэмлэхийг холбогдох байгууллагаас бичгээр ирүүлсэн хүсэлт болон цагдаагийн байгууллагын тодорхойлолтыг үндэслэн олгоно. Нэвтрэх үнэмлэхэд дор дурдсан зүйлийг тусгана:

4.9.1. үнэмлэх эзэмшигчийн зураг, овог нэр, эрхэлж байгаа ажил, албан тушаал;

4.9.2. үнэмлэхийн хүчинтэй байх хугацаа;

4.9.3. үнэмлэхийн хүчин төгөлдөр үйлчлэх бүс;

4.9.4. үнэмлэхийг ашиглахтай холбогдсон зааварчилга.

4.10. Хамгаалагдсан бүсэд нэвтрэх тээврийн хэрэгсэлд үнэмлэх олгохдоо холбогдох байгууллагаас ирүүлсэн хүсэлтийг үндэслэнэ. Тээврийн хэрэгслийн нэвтрэх үнэмлэхэд дор дурдсан зүйлийг тусгана:

4.10.1. тээврийн хэрэгслийн бүртгэлийн дугаар;

4.10.2. тээврийн хэрэгслийг эзэмшигч /ашиглагч/-ийн нэр, таних тэмдэг;

4.10.3. нэвтрэх үнэмлэхийн хүчинтэй байх хугацаа;

4.10.4. үнэмлэхийн хүчин төгөлдөр үйлчлэх бүс.

4.11. Хамгаалагдсан бүсэд нэвтрэх тээврийн хэрэгслийн тоонд хязгаарлалт тогтоож болно.

4.12. Агаарын тээвэрлэгч нь хамгаалагдсан бүсэд байгаа агаарын хөлгийн аюулгүй байдлыг хангах талаар дараахь арга хэмжээ авна:

4.12.1. үйлчилгээ хийгдээгүй үед агаарын хөлгийн бүх хаалгыг хааж түгжих;

4.12.2. зорчигч болон ачаа тээш ачих, буулгах төхөөрөмжийг холдуулах;

4.12.3. нислэгийн өмнө агаарын хөлгийн аюулгүй байдлын үзлэг хийх.

Тав. Аюулгүй байдлын үзлэг

5.1. Аюулгүй байдлын үзлэг хийхдээ дараахь тоног төхөөрөмжийг ашиглах бөгөөд цахилгааны саатал болон гэмтэл гарах шалтгаанаар тоног төхөөрөмж ашиглах боломжгүй үед зорчигчийн бие, гар тээшинд биечлэн үзлэг хийнэ:

- металл илрүүлэгч гар багаж болон хаалга;
- рентген туяаны аппарат;
- тэсрэх бодис илрүүлэгч;
- бусад.

5.2. Аюулгүй байдлын үзлэгт орсон зорчигчдыг тусгайлан бэлтгэсэн үзлэгийн дараахь бүсэд нэвтрүүлэн тусгаарлана.

5.3. Заналхийллийн түвшин өндөр үед зорчигч, тэдгээрийн гар тээшинд хийх үзлэгийг сонголтын журмаар гүйцэтгэж болно. Нэг нислэгт сонголтын журмаар хийгдэх үзлэгийн доод хэмжээг Ерөнхий газраас тогтооно.

5.4. Аюулгүй байдлын үзлэгээр зэвсэг, тэсэрч дэлбэрэх зүйл, аюултай ачаа илэрсэн тохиолдолд хураан авч тагнуулын болон цагдаагийн байгууллагад мэдэгдэнэ.

5.5. Эрх бүхий байгууллагаас тээвэрлэхийг зөвшөөрсөн зэвсэг, тэсэрч дэлбэрэх зүйл, аюултай ачааг зорчигчдоос тусгаарлан агаарын хөлгийн ачааны хэсэгт тээвэрлэнэ.

5.6. Аюулгүй байдлын үзлэгээс татгалзсан болон зайлсхийсэн зорчигчийг үзлэгийн дараахь бүсэд нэвтрүүлэхгүй бөгөөд агаарын хөлгөөг тээвэрлэхгүй.

5.7. Аюулгүй байдлын үзлэгээр ороогүй зорчигч үзлэгийн дараахь бүс болон агаарын хөлөгт нэвтрэсэн тохиолдолд дараахь арга хэмжээ авна:

5.7.1 үзлэгийн дараахь бүсийг бүрэн чөлөөлж, дахин шалгана;

5.7.2 зорчигч, тэдгээрийн гар тээшийг үзлэгт дахин оруулна;

5.7.3 агаарын хөлөгт үзлэгт хамрагдаагүй зорчигч байгааг илрүүлсэн тохиолдолд агаарын хөлгийг дахин шалгана.

5.8. Хамгаалагдсан болон үзлэгийн дараахь бүсэд нэвтрэх байгаа агаарын хөлгийн багийн гишүүд, хилийн болон хил хяналтын байгууллагын ажилтан, төрийн хамгаалалтын ажилтан, үйлчилгээний бусад ажилтнууд аюулгүй байдлын үзлэгт хамрагдана.

5.9. Дипломат эрх бүхий ажилтан аюулгүй байдлын үзлэгт хамрагдана. Дипломат эрх бүхий ажилтныг гар тээш, тээшинд үзлэг хийхдээ өөрийг нь, эсхүл түүнийг төлөөлөх бүрэн эрхт төлөөлөгчийг байлцуулна.

5.10. Зохих журмын дагуу лацадсан дипломат шуудангийн илгээмжид аюулгүй байдлын үзлэг хийхгүй. Төрийн нууцын зэрэглэлтэй ачаа, шуудангийн илгээмжид зөвхөн тоног төхөөрөмжийн тусламжтайгаар аюулгүй байдлын үзлэг хийнэ.

5.11. Төрийн тусгай хамгаалалтад байгаа албан тушаалтан, иргэнийг аюулгүй байдлын үзлэгээс чөлөөлнө.

5.12. Их хэмжээний үнэт зүйл авч яваа зорчигч, хөгжлийн бэрхшээлтэй болон зүрхний аппараттай зорчигчдод аюулгүй байдлын үзлэгийг тусад нь хийнэ.

5.13. Ажил үүргээ гүйцэтгэж яваа хууль хяналтын байгууллагын болон төрийн тусгай хамгаалалтын ажилтан нь зорчигчийн бүхээгт зэвсэг, хэрэгслийг биедээ авч явж болно. Биедээ зэвсэг авч яваа зорчигчийг дараахь шаардлагыг хангасан нөхцөлд тээвэрлэнэ:

5.13.1. зэвсэг авч явахыг зөвшөөрсөн эрх бүхий байгууллагын зөвшөөрөлтэй байх;

5.13.2. зэвсэг авч яваа зорчигчид согтууруулах ундааны зүйлээр үйлчлэхгүй байх;

5.13.3. зэвсэг авч яваа зорчигчийн тоо болон тэдгээрийн суудлын байршлыг нислэг эхлэхээс өмнө агаарын хөлгийн дэргэд мэдэгдэх.

5.14. Агаарын тээвэрлэгч нь хууль хяналтын байгууллагын хяналтад байгаа зорчигчийг харгалзагчийн хамт, бие даан зорчих чадваргүй

сэтгэтийн өвчтэй зорчигчийг асран хамгаалагчийн хамт тус тус тээвэрлэнэ.

5.15. Агаарын тээвэрлэгч нь аюулгүй байдлын үзлэг хийгдсэн, бүртгэгдсэн тээшийг зөвхөн тийз бүхий зорчигчоос, шилжин ачигдах тээшийг агаарын тээвэрлэгчийн эрх бүхий төлөөлөгчөөс хүлээн авч тээвэрлэнэ.

5.16. Агаарын тээвэрлэгч нь зорчигчийг агаарын хөлөгт суулгахаас өмнө түүний бичиг баримт, суугчийн тасалбарыг зорчигчийн нэрсийн жагсаалттай тулган шалгаж, тээшээ тээвэрлүүлэхээр бүртгүүлсэн зорчигч мөн болохыг давхар хянана.

5.17. Бүртгэгдсэн тээш нь тээвэрлэлтэд хүлээн авснаас хойш аяллын төгсгөлд зорчигчид эргүүлж олгох хүртэл, шилжин суух зорчигчийн тээшийг өөр агаарын тээвэрлэгчийн мэдэлд шилжүүлэх хүртэл хугацаанд тухайн агаарын тээвэрлэгчийн хамгаалалтад байлгана.

5.18. Шилжин суух зорчигчийн бүртгэгдсэн тээшинд аюулгүй байдлын үзлэг хийнэ. Нисэх буудлын захиргаа болон агаарын тээвэрлэгч нь дамжин өнгөрөх, шилжин суух зорчигчийг агаарын хөлгөөр тээвэрлэхийг хориглосон бодис, зүйлийг агаарын хөлөгт авч орохоос урьдчилан сэргийлэх арга хэмжээ авна.

5.19. Аяллаас хоцорсон, эсхүл тээвэрлэлтийн гэрээ нь цуцлагдсан тохиолдолд зорчигчийн бүртгэгдсэн тээшийг агаарын хөлгөөр тээвэрлэхийг хориглоно.

5.20. Ачаа болон шуудангийн илгээмжийг агаарын хөлөгт ачихаас өмнө аюулгүй байдлын үзлэг хийнэ. Тээвэрлэлтэд хүлээн авсан ачаа, шуудангийн илгээмжийн хадгалалт, хамгаалалтыг агаарын хөлөгт ачих хүртэл нисэх буудлын захиргаа хариуцна.

5.21. Алдагдсан, эсхүл эзэнгүй тээшийг аюулгүй байдлын үзлэгт оруулсны дараа тээш хадгалах газарт хадгална.

Зургаа. Аюулгүй байдлын тоног төхөөрөмж

6.1. Аюулгүй байдлын тоног төхөөрөмжийн хангалт, шинэчлэлтийн асуудлыг Ерөнхий газар хариуцна.

6.2. Нисэхийн аюулгүй байдлын үйл ажиллагаанд ашиглах тоног төхөөрөмжийг худалдан авах, шинэчлэхдээ Олон улсын иргэний нисэхийн байгууллагын зөвлөмжийг удирдлага болгоно.

6.3. Аюулгүй байдлын тоног төхөөрөмжид тохируулга хийхдээ тухайн төхөөрөмжийг үйлдвэрлэгчээс ирүүлсэн тест материалыг ашиглана.

6.4. Аюулгүй байдлын тоног төхөөрөмжийн тохируулгыг жилд нэг удаа хийж, Ерөнхий газраар баталгаажуулна.

6.5. Заналхийллийн түвшингээс хамаарч тоног төхөөрөмжийн мэдрэх чадварыг бууруулах буюу нэмэх асуудлыг Ерөнхий газрын зөвшөөрлийн үндсэн дээр шийдвэрлэнэ.

Долоо. Аюулгүй байдлын ажилтан

7.1. Аюулгүй байдлын ажилтан нь иргэний нисэхийн аюулгүй байдлын сургалтын хөтөлбөрийг дагуу сургалтад хамрагдаж, мэргэжлийн үнэмлэх авснаар нисэхийн аюулгүй байдлын үзлэг хийх эрхтэй болно.

7.2. Аюулгүй байдлын ажилтныг уг ажилд томилохын өмнө гэмт хэрэг, хэв журмын зөрчилд холбогдож байсан эсэхийг нь судалж тогтоосон байна.

Найм. Нисэхийн аюулгүй байдлын сургалт

8.1. Иргэний нисэхийн аюулгүй байдлын үйл ажиллагаанд хүний хүчин зүйлийн нөлөөллийг сайжруулах, хүний гүйцэтгэх үүрэг, хариуцлага, мэдлэг чадварыг дээшлүүлэх зорилгоор аюулгүй байдлын сургалтыг зохион байгуулах бөгөөд сургалтад тавигдах шаардлагыг иргэний нисэхийн аюулгүй байдлын сургалтын хөтөлбөрт тодорхой тусгасан байна.

8.2. Иргэний нисэхийн аюулгүй байдлын сургалтын хөтөлбөрийг Ерөнхий газраас боловсруулж иргэний нисэхийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагаар баталгаажуулан хэрэгжүүлнэ.

Ес. Хөндлөнгийн хууль бус үйлдлийн эсрэг авах арга хэмжээ

9.1. Агаарын тээвэрлэгч, нисэх буудлын захиргаа нь хөндлөнгийн хууль бус үйлдэл гарсан тохиолдолд хууль хяналт, цэрэг, цагдаа, онцгой байдлын болон холбогдох бусад байгууллагатай хамтран нисэх буудлын онцгой байдлын үед ажиллах журмын дагуу ажиллана.

9.2. Онцгой байдлын үед ажиллах байгууллагууд нь хамтарсан сургуулилтыг тодорхой хугацаанд тогтмол зохион байгуулна.

9.3. Нислэг үйлдэж байгаа агаарын хөлөгт хөндлөнгийн хууль бус үйлдэл гарсан тохиолдолд нислэгийн хөдөлгөөний үйлчилгээний алба нь нислэгийн маршрутын дагуу байгаа болон дайран өнгөрч болзошгүй нислэгийн хөдөлгөөний удирдлагын байгууллагад энэ талаар нэн даруй мэдэгдэнэ.

9.4. Хөндлөнгийн хууль бус үйлдэлд өртсөн агаарын хөлөгт агаарын навигацгийн болон нислэгийн хөдөлгөөний удирдлагын үйлчилгээг үргэлжлүүлэн үзүүлнэ.

9.5. Хууль бусаар эзлэгдсэн агаарын хөлгийг Монгол Улсын нутаг дэвсгэр дээр газардахыг зөвшөөрөх бөгөөд хяналтаас гараагүй үед уг агаарын хөлгийг хөөрөхгүй байх бүх талын арга хэмжээ авна.

9.6. Хөндлөнгийн хууль бус үйлдэлд өртсөн агаарын хөлөг Монгол Улсын нутаг дэвсгэр дээр газардсан тохиолдолд тухайн агаарын хөлгийг бүртгэсэн болон ашиглагч улсад; хөндлөнгийн хууль бус ажиллагаанд өртсөн болон түүний улмаас нас барсан, гэмтэж бэртсэн, эсхүл барьцаалагдсан хүмүүсийн талаархи мэдээллийг тэдгээрийн харьяалах улсад тус тус мэдэгдэнэ.

9.7. Хөндлөнгийн хууль бус үйлдэл гарсан талаархи мэдээллийг Олон улсын иргэний нисэхийн байгууллагад англи хэл дээр, энэхүү үйлдлийн тухай урьдчилсан мэдээллийг тухайн үйл явдал болсноос хойш 30 хоногийн дотор, эцсийн мэдээллийг тухайн үйл явдал болсноос хойш 60 хоногийн дотор хүргүүлнэ.

Арав. Чанарын хяналт

10.1. Иргэний нисэхийн аюулгүй байдлыг хангах арга хэмжээ нь олон улсын гэрээ, хэлэлцээ, үндэсний хууль тогтоомжид нийцэж байгаа, тухайн үеийн заналхийллийн түвшинд тохирч байгаа

эсэхийг хянан шалгах ажиллагааг иргэний нисэхийн аюулгүй байдлын чанарын хяналтын хөтөлбөрт тусган хэрэгжүүлнэ.

10.2. Иргэний нисэхийн аюулгүй байдлын чанарын хяналтын хөтөлбөрийг Ерөнхий газраас боловсруулан, иргэний нисэхийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагаар баталгаажуулна.

10.3. Ерөнхий газар нь нисэх буудал, агаарын тээвэрлэгч, нисэхийн аюулгүй байдлын үйлчилгээний болон нислэгийн хоол хүнс бэлтгэх байгууллагын аюулгүй байдлыг хангах үйл ажиллагаанд жилд нэгээс доошгүй удаа үзлэг шалгалт хийж, илэрсэн дутагдлыг засаж залруулах арга хэмжээ авна.

Арван нэг. Иргэний нисэхийн эсрэг заналхийллийн түвшинг тогтоох

11.1. Ерөнхий газар, тагнуулын болон цагдаагийн байгууллага нь иргэний нисэхийн эсрэг заналхийллийн түвшинг хамтран тодорхойлно.

11.2. Иргэний нисэхийн эсрэг заналхийллийн түвшинг тодорхойлох, тогтоох, тухайн түвшинд тохирох арга хэмжээг хэрэгжүүлэх, заналхийллийн талаархи мэдээлэлтэй харьцах, нууцлахтай холбогдсон асуудлыг Иргэний нисэхийн эсрэг заналхийллийн түвшин тогтоох журамд тусган хэрэгжүүлнэ.

Арван хоёр. Нисэхийн аюулгүй байдлын үйл ажиллагааны санхүүжилт

12.1. Энэхүү хөтөлбөрийн дагуу нисэхийн аюулгүй байдлыг хангах үүрэг хүлээсэн байгууллагууд нь хариуцсан үүргээ хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг төсөвтөө тусган санхүүжүүлнэ.

Мэргэлд Улсын Их Хурлын Тамгын газраас гаргав.
Хаяг: <<Төрийн мэдээлэл>> эмхтгэлийн зөвлөл.

Улсын Их Хурлын Тамгын газрын
Хэвлэх хэсэгт хэвлэв.

Улаанбаатар-12
Төрийн ордон

☎ 265958
Индекс 14003

☎ 329487
Хэвлэлийн хуудас 2.5